(албан хаагчийн нэр)
2024.06.10 (огноо)

Үнэлгээ хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:
Дотоод хяналт, шинжилгээний хэлтсийн
дарга
(албан тушаал)



/ Э.Даваахатан /
(албан хаагчийн нэр)
2024.06.20 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөц хариуцсан Ахлах мэргэжилтэн
(албан тушаал)



(гарын үсэг)

/ П.Отгонцэрэн /
(албан хаагчийн нэр)
2024.06.20 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Хяналт шалгалтын
газрын дарга

(албан тушаал)



(гарын үсэг)

/С.Төмөрдулам/

(албан хаагчийн нэр)

2024.06.20 (огноо)

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН МАНДАХЫН ГАЧМААГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|--|--|---------------------------------------|---------------------|---|--|---------------------------|-----------------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин (эхний хагас жил) | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. Чанарын удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэх | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартын давтан баталгаажуулалтыг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэх, гэрчилгээ авах. (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1) | Баталгаажуулалт хийгдсэн байна | - | Чанарын удирдлагын баг байгуулж, хөтөлбөр боловсруулсан байна | Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар чанарын удирдлагын стандартын гэрчилгээний баталгаажуулалтыг байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах үүрэг бүхий Чанарын удирдлагын баг байгуулж, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган батлуулсан. Газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд хойшлогдсон. | 2024.03.01- 2024.06.10 | 100% |
| Зорилт 2. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад чанарын удирдлагын тогтоцоог нэвтрүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. /НХТЖҮЧ-5.3/ | | | | | | | |
| 2. | Арга хэмжээ 2.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2016, MNS ISO 18091 стандартыг үйл ажиллагаанд | Стандарт нэвтрүүлсэн байгууллагын тоо | 20 | Зохион байгуулах арга хэмжээнд оролцож хамтран | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас энэ арга хэмжээний талаар хамтран ажиллах шийдвэр гараагүй байна. | 2024.01.02- 2024.06.10 | 100% |

| | | | | | | | |
|--|---|--|-----|---|---|-----------------------|------|
| | нэвтрүүлэх талаар зөвлөмж, арга зүйгээр хангах, хамтран ажиллах. (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1) | | | ажилласан байна | | | |
| Зорилт 3. Төрийн байгууллагын дотоод засаглалын үйл ажиллагааг тогтмол сайжруулах, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх. | | | | | | | |
| 3. | Арга хэмжээ 3.1. Байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, цаг үеийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг нэгтгэн тайлагнаж удирдлагыг мэдээллээр хангана (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 7.1) | Төлөвлөсөн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | 389 | Төлөвлөгөөг сар бүр батлуулж, биелэлтийг нэгтгэн гаргаж тайлагнасан байна | Байгууллагын сарын ажлын төлөвлөгөөг 7 бүлгийн хүрээнд хэлтсүүдээс санал авч нэгтгэн боловсруулж, газрын даргаар батлуулан хэрэгжилтийг хангуулсан. 2024 оны 1-4 дүгээр сарын цаг үеийн ажлын төлөвлөгөөнд нийт 182 арга хэмжээг төлөвлөж, биелэлтийг нэгтгэн хэлтсийн даргад танилцуулж баталгаажуулсан. Газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой 5, 6 дугаар сарын төлөвлөгөө гараагүй. | 2024.01.02-2024.06.10 | 100% |
| Зорилт 4. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах хүрээнд бүртгэл мэдээллийг хөтлөх | | | | | | | |
| 4. | Арга хэмжээ 4.1. Хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд өгсөн санал (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 8.1.1) | Төрөл, тоо | 17 | Саналыг нэгтгэж удирдлагын зөвлөлд танилцуулсан байна | Байгууллагын хэмжээнд дараах хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. Үүнд: - Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр-3; - Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд- 2; - "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төсөлд- 2; - Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт- 2; | 2024.01.02-2024.06.10 | 90% |

| | | | | | | | |
|----|--|------------|---|--|--|-----------------------|------|
| | | | | | <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн эдийн засаг нийгмийн хөгжлийн 2025 төлөвлөгөөний төсөлд- 5; - "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийслэлийн салбар зөвлөл"-ийн 2025 оны төлөвлөгөөний төсөл- 3; - Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 385 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө-7. | | |
| 5. | <p>Арга хэмжээ 4.2. Газар, нэгжийн үйл ажиллагаанд холбоотой хууль, тогтоомж, дүрэм, журам, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, үүрэг даалгаврууд</p> <p>(Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 8.1.3)</p> | Төрөл, тоо | - | <p>Шийдвэрүүдийг үүрэгжүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна</p> | <p>Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийг газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын дагуу бүртгэл-хяналтын картаар хариуцан шийдвэрлэх нэгж, албан хаагчдад шилжүүлж, шийдвэрийг хяналтад авч байгууллагын дотоод сүлжээний "Тогтоол шийдвэр"-т тогтмол байршуулан ажиллаж байна. 2024 онд бүртгэлд байгаа тогтоол шийдвэрүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Хууль тогтоомж: 11 - Засгийн газрын тогтоол: 3 - Засгийн газрын хуралдааны тэмдэглэл: 4 - Улсын онцгой комиссын шийдвэр: 2 - Нийслэлийн онцгой комиссын үүрэг даалгавар: 2 - НИТХ-ын тогтоол: 17 - Нийслэлийн Засаг даргын захирамж: 41 - Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл: 2 /дугаар 01, 06/ - Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр | 2024.01.02-2024.06.10 | 100% |

| | | | | | | | |
|----|--|------------|----|--|--|---------------------------|------|
| | | | | | Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгавар: 58 - Хяналт шалгалтын газрын дүрэм, дотоод журам, бусад. | | |
| 6. | Арга хэмжээ 4.3. Ажлын хэсэгт ажилласан мэдээлэл (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 8.1.4) | Төрөл, тоо | 60 | Бүртгэлийг тухай бүр хөтөлж, биелэлтийг нэгтгэн гаргаж тайлагнасан байна | Газрын удирдлага болон албан хаагчид Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан нийт 23 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж байна. Үүнд: - Ахлагч: 2 - Нарийн бичгийн дарга: 1 - Гишүүн: 20 Захирамжийн хагас жилийн хэрэгжилтийг Дотоод хяналт шинжилгээний хэлтэст хүргүүлэхээр хариуцсан хэлтсүүдээс биелэлтийг нэгтгэж байна. | 2024.01.02- 2024.06.10 | 90% |
| 7. | Арга хэмжээ 4.4. Газрын удирдлагын тушаал, шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын бүртгэл (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 8.1.7) | Төрөл, тоо | 77 | Тушаал шийдвэрийн хэрэгжилт хангуулж, биелэлт гаргаж тайлагнасан байна | Хяналт шалгалтын газрын даргаас байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр нийт 19 А тушаал батлагдаж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Үүнд: - Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой: 3, - Дүрэм, журам батлах: 1, - Ажлын хэсэг, баг бүрэлдэхүүн томилох: 6, - Төлөвлөгөө батлах: 1, - Зардал хөрөнгө гаргах: 1, - Комиссын үйл ажиллагаатай холбоотой: 1, - Төрийн хяналт шалгалттай холбоотой: 2, - Бусад 3. Нэгж, албан хаагчдын боловсруулсан тушаалын төслийг хянаж газрын даргаар | 2024.01.02- 2024.06.10 | 100% |

баталгаажуулан дугаар олгож,
бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Зорилт 5. Засгийн газрын сайдуудтай хийх гэрээ, Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, газрын үндсэн чиг үүргийн биелэлтийг нэгтгэх

| | | | | | | | |
|----|--|---------------------------------|---|--|---|---------------------------|------|
| 8. | <p>Арга хэмжээ 5.1. Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан хамтран ажиллах гэрээнд газрын чиг үүрэгт хамаарах ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 9.1)</p> | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 6 | Гэрээний биелэлтийг нэгтгэн гаргаж тайлагнасан байна | <p>Дараах 2 салбарын сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний газрын чиг үүрэгт хамаарах заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">1. Барилга хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээний 16 заалт;2. Эрчим хүчний сайдтай байгуулсан гэрээний 7 заалт. <p>Гэрээний 1-р улирлын хэрэгжилтийг нэгтгэн газрын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн хуралд 2024 оны 04 дүгээр 02-ны өдөр танилцуулсан. /Барилга, хот байгуулалтын сайд- 87.4%, Эрчим хүчний сайд- 88%/</p> <p>Хагас жилийн хэрэгжилтийг хариуцсан хэлтсүүдээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.</p> | 2024.01.02- 2024.06.10 | 100% |
| 9. | <p>Арга хэмжээ 5.2. Улс, нийслэлийг хөгжүүлэх богино, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг тогтоосон хугацаанд нэгтгэх, тайлагнах (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 9.2)</p> | Үйл ажиллагааны хэрэгжилт хувь | 5 | Биелэлтийг нэгтгэн гаргаж тайлагнасан байна | <ol style="list-style-type: none">1. Улс, нийслэлийг хөгжүүлэх богино, дунд хугацааны дараах 6 бодлогын баримт бичигт тусгагдсан газрын чиг үүрэгт хамаарах нийт 28 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:<ul style="list-style-type: none">- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого- 4 арга хэмжээ;- "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн | 2024.01.02- 2024.06.10 | 100% |

| | | | | | | | |
|-----|---|--|----|--|---|------------------------------|-----|
| | | | | | <p>чиглэл"- 4 зорилтын 5 арга хэмжээ;</p> <ul style="list-style-type: none"> - "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"- 8 арга хэмжээ; - "Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"- 6 арга хэмжээ; - "Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө"- 1 зорилт, 3 арга хэмжээ; - "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр- 2 арга хэмжээний хэрэгжилтийг сар бүр НЗДТГ-т тайлагнаж байна. <p>Дээрх бодлогын баримт бичгийн 2024 оны 1-р улирлын биелэлтийг нэгтгэн 2024 оны 04 сарын 02-ны өдөр газрын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан.</p> <p>2. Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг 2024 оны 05 сарын 16-ны өдөр ERP Хяналт шинжилгээ үнэлгээ системээр НЗДТГ-т тайлагнасан. /дундаж хэрэгжилт 58.3%/</p> | | |
| 10. | <p>Арга хэмжээ 5.3. Байгууллагын үндсэн чиг үүрэгт холбогдолтой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг удирдлагын цохолт хийлгэн, хяналтад авсан заалтын хэрэгжилтийг нэгтгэх, тайлагнах (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 9.3)</p> | <p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p> | 58 | <p>Шийдвэрийн тухай бүр цохуулж, биелэлтийг нэгтгэн гаргаж тайлагнасан байна</p> | <p>Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийг газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын дагуу бүртгэл-хяналтын картаар хариуцан шийдвэрлэх нэгж, албан хаагчдад шилжүүлж, шийдвэрийг хяналтад авч ажиллаж байна.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар газрын хэмжээнд хяналтад авсан нийт 35 тогтоол шийдвэрийн</p> | <p>2024.01.02-2024.06.10</p> | 90% |

| | | | | | | | |
|-----|--|---------------------------------|---|---|--|-----------------------|------|
| | | | | | эхний хагас жилийн биелэлтийг нэгтгэхээр нийт нэгжүүдэд жагсаалт гаргаж хүргүүлж хэрэгжилтийг нэгтгэв. | | |
| 11. | <p>Арга хэмжээ 5.4. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын үүрэг даалгавар, Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, мэдээг тухай бүр заагдсан хугацаанд тайлагнах</p> <p>(Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 9.4)</p> | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | Биелэлтийг нэгтгэн гаргаж тайлагнасан байна | <p>Газрын чиг үүргийн хүрээнд өгөгдсөн дараах үүрэг даалгавар, тайлан мэдээг тухай хугацаанд нь тайлагнаж ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийслэлийн удирдах ажилтнуудын 11 удаагийн шуурхай хуралдаанаас Нийслэлийн Засаг даргаас өгсөн газрын чиг үүрэгт хамаарах нийт 58 үүрэг даалгавар (үндсэн хэрэгжүүлэх 20)-ын биелэлтийг удирдлагаар баталгаажуулан ERP-Хяналт шинжилгээ үнэлгээ дэд системээр тухай бүр НЗДТГ-т; (дундаж хэрэгжилт: 85%) 2. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2 хуралдааны тэмдэглэлээр өгсөн нийт 11 үүрэг даалгаврын биелэлтийг 2024.01.04-ний өдөр НЗДТГ-т: <ul style="list-style-type: none"> - 2023.12.15-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэл-2 үүрэг даалгавар 70%. - 2023.12.26-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл-9 үүрэг даалгавар 34.4%. 3. Нийслэлийн Засаг даргаас цаг үеийн асуудлаар 3-р сарын 15-ны өдөр өгсөн 1 үүрэг даалгаврын биелэлтийг 2024.05.08-ны өдөр НЗДТГ-т; (хэрэгжилт: 100%) 4. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас 2023 оны 10 дугаар сараас хойш хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024.04.09-ний өдрийн | 2024.01.02-2024.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---------------------------------|---|---|---|---------------------------|------|
| | | | | | 01/456 дугаартай албан бичгээр НЗДТГ-т; 5. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамж "Тохжилт-Бүтээн байгуулалтын жил"-ийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлтийг 2024.04.05-ны өдрийн 01/435 дугаартай албан бичгээр НЗДТГ-т тус тус хүргүүлэв. | | |
| Зорилт 6. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх. | | | | | | | |
| 12. | Арга хэмжээ 6.1. ХАСХОМ (Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг)-ийг мэдүүлэх эрх бүхий албан хаагчид гаргаж өгөх (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 13.1) | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 2023 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хугацаанд нь мэдүүлсэн байна. | 2023 оны "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг холбогдох хууль тогтоомжийн хугацаанд https://meduuleg.iaac.mn цахим системд тайлагнаж, баталгааны маягыг 2024 оны 02 сарын 01-ний өдөр эрх бүхий албан тушаалтан хүргүүлсэн. | 2024.01.02- 2024.06.10 | 100% |
| Зорилт 7. Бусад нийтлэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын дэргэд ажиллах зөвлөлүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх. | | | | | | | |
| 13. | Арга хэмжээ 7.1. Байгууллагын дэргэдэх зөвлөлүүдийг шинэчлэн байгуулах (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 14.1) | Зөвлөлийн тоо | 5 | Зөвлөлүүдийн тушаалыг албажуулсан байна | Байгууллагын дэргэдэх орон тооны бус дараах 10 зөвлөлийг 2024 оны 3 дугаар сард газрын даргын тушаалаар байгуулсан. Үүнд: 1. Чанарын баг- А/09 2. Ёс зүйн дэд хороо- А/10 3. Залуучуудын зөвлөл- А/11 4. Биеийн тамир, спорт хамтлаг- А/12 5. Эцэг эхийн зөвлөл- А/13 6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл- А/14 7. Өмч хамгаалах байнгын зөвлөл- А/16 8. Баримт бичиг нягтлан шалгах комисс- А/17 | 2024.03.01- 2024.06.10 | 100% |

| | | | | | | | |
|--|--|--|---|--|--|------------------------------|-------------|
| | | | | | <p>9. Эрсдэлийн удирдлагын баг- A/18</p> <p>10. Хүний эрх, жендерийн эрхийн зөвлөл- A/20</p> <p>Газрын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан 2024.05.21-ний өдрийн A/13 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулаад байна. Мөн газрын даргын 2024.06.06-ны өдрийн A/20 дугаар тушаалаар Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги байгуулав.</p> | | |
| 14. | <p>Арга хэмжээ 7.2. Зөвлөлүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжүүлэх /Нийслэлийн хэмжээнд зохион байгуулж буй олон талт арга хэмжээ, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, спортын наадам, цасны баяр, мэтгэлцээн гэх мэт бусад тэмцээнд оролцох/</p> <p>(Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 14.2)</p> | <p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p> | - | <p>Зөвлөлүүдийн зохион байгуулах арга хэмжээнд идэвхтэй оролцсон байна</p> | <p>Нийслэлийн хэмжээнд болон байгууллагын хэмжээнд зохион байгуулсан дараах арга хэмжээнд идэвхтэй оролцлоо. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулсан "CITY STANDART CUP" спортын таван төрөлт тэмцээн; - Хувь хүний хөгжлийн институт, Хүний эрх, жендерийн зөвлөл Жендерийн үндэсний хорооноос "Харилцаа ба хүндлэл" - "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо, Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн "IGM"-д мод тарих арга хэмжээ; - Бүх нийтийн их цэвэрлэгээнд 4, 5 сард 2 удаа; - "Улаанбаатар Марафон-2024" олон улсын гүйлтийн тэмцээний 5км төрөлд. - НЗДТГ-аас нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдын дунд зохион байгуулсан UB QUIZ-385 танин мэдэхүйн тэмцээн. | <p>2024.03.01-2024.06.10</p> | <p>100%</p> |
| <p>Зорилт 8. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх.</p> | | | | | | | |

| | | | | | | | |
|-----|--|---------------------------------|---|------------------------------------|---|-----------------------|------|
| 15. | Арга хэмжээ 8.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах (Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 15.1) | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна | Энэ хууль болон Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон байгууллагын дотоод дүрэм, журмыг баримтлан ажиллаж байна. | 2024.01.02-2024.06.10 | 100% |
|-----|--|---------------------------------|---|------------------------------------|---|-----------------------|------|

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|--|--------------------------------------|---------------------|--------------------------------|---|--------------------------|-----------------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин (эхний хагас жил) | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |
| 6 | | | | | | | |
| 7 | | | | | | | |
| Зорилт 1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1. НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулах мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалтад хамрагдах | Сургалтын хөтөлбөрт хамрагдсан байна | - | 50% | НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2024 онд зохион байгуулагдах дараах сургалтад хамрагдах санал хүргүүлсэн. - Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй; - MS Excel (дунд шатны) сургалт; - Зөрчлийг удирдахуй; - Судалгааны арга зүй ахисан шат. Тайлант хугацаанд Хүний нөөцийн хөгжлийн төвөөс сургалт зохион байгуулаагүй бөгөөд 3-р улирлаас танхимын болон "Нийслэл академи"-ийн онлайн сургалтуудад хамрагдахаар төлөвлөж байна. | 2024.01.02-2024.06.10 | 90% |
| 2. | Арга хэмжээ 2. Байгууллагын чиг үүргийн хүрээнд салбарын | Хууль тогтоомж | - | 50% | Албан тушаалын чиг үүргийн хүрээнд тушаал боловсруулах, байгууллагын үйл | 2024.01.02-2024.06.10 | 90% |

| | | | | | | | |
|----|---|-----------------------------------|---|---|--|-----------------------|-----|
| | хууль тогтоомжийн мэдлэгээ дээшлүүлэх | судалсан байна | | | ажиллагааны хэрэгжилт, үр дүнг холбогдох дээд шатны байгууллагад тайлагнах хүрээнд Барилгын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн мэдлэгийг тогтмол дээшлүүлэн ажиллаж байна. | | |
| 3. | Арга хэмжээ 3. Хэвлэлийн эх, постер, дизайн боловсруулах программ хангамжийн сургалтад хамрагдах /Ps, Ai, Id гэх мэт/ | Онлайн сургалтад хамрагдсан байна | - | - | 2024 оны 3 дугаар улирлаас эхлэн уг сургалтад хамрагдахаар төлөвлөж байна. | 2024.06.01-2024.12.31 | 90% |

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

(Албан тушаал)


 /Б.МӨНХБАЯР/
 (Нэр, гарын үсэг)


2024.06.10

 (Огноо)

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)


 /М.ГАЧМАА/
 (Нэр, гарын үсэг)

2024.06.10

 (Огноо)

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
БАЯНДАЛАЙН САРАНГЭРЭЛИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|--------------------------------|---------------------|--------------------------------------|---|---------------------------|-----------------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. Газрын үндсэн чиг үүрэгтэй холбогдох хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох. | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Үндсэн чиг үүрэгтэй холбоотой асуудлаар хууль, эрх зүйн орчны судалгаа хийх, шаардлагатай хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, дээд шатны байгууллагад уламжлах. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувь | - | Саналыг боловсруулж хүргүүлсэн байна | - НЗД-ын 2024.01.02-ны өдрийн А/01 дугаартай захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан "Тохижилт бүтээн байгуулалтын ажилд саад учруулдаг хуулийн судалгаа хийх, сайжруулах санал боловсруулах дэд ажлын хэсэг"-ийн хүрээнд хууль тогтоомжийн судалгаа хийж, 2 хуулийн 4 зүйл болон шинээр журам боловсруулах саналыг ажлын хэсгийн ахлагч ХЭЗГД Д.Амгаланд; - НЗД-ын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/1329 дүгээр захирамжаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнд тус газрын дарга нь томилогдсон тул Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд | 2024.01.01- 2024.06.10 | 100% |

| | | | | | | | |
|----|--|------------------------------------|--|--------------------------------------|--|-----------------------|------|
| | | | | | <p>хөрөнгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор салбарын хүрээнд холбогдох судалгааг хийж, Ажлын хэсгийн хуралдаанд 3-н удаа оролцож, Хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөлд санал боловсруулан ажилласан.</p> <p>- Бусад:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн дагуу боловсруулагдаж буй "Цэцэрлэг, ногоон байгууламж, авто зогсоолын шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгөд нэмэгдүүлсэн хувиар албан татвар ногдуулах журам"-ын төсөлд санал боловсруулж, 2024.02.09-ний 01/135 дугаартай албан бичгээр НЗДТГ-хүргүүлэв. /7/ ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль-2024.04.15 01/483-НЗДТГ /3/ ✓ Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хуулийн төсөл-2024.03.25 01/381 /8/ ✓ Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл /3/ ✓ Ёс зүйн дэд хорооны ажиллах журам /3/ | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах | Боловсруулж хүргүүлсэн саналын тоо | | Саналыг боловсруулж хүргүүлсэн байна | "Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал", НЗД-ын албан бичгийн төслийг боловсруулж, НЗД-ын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/135 дугаар албан бичгээр | 2024.01.01-2024.06.10 | 100% |

45

| | | | | | | | |
|--|---|------------------------------------|---|---|--|-----------------------|------|
| | дүрэм"-д өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх | | - | | Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. /5 санал/ | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын ажиллах зардлын хэмжээг барилга байгууламжийн төвөгшил, хэм хэмжээг харгалзан тогтооход санал боловсруулж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх | Боловсруулж хүргүүлсэн саналын тоо | | Саналыг боловсруулж хүргүүлсэн байна | "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах жишиг зардлыг тооцох тухай БХБС-ын тушаалын төсөл", НЗД-ын албан бичгийн төслийг боловсруулж, НЗД-ын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/135 дугаар албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. /1 санал-хүснэгтээр/ | 2024.01.01-2024.06.10 | 100% |
| 4. | Арга хэмжээ 1.4. Албан хаагчдад хууль, эрх зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт хувь | | Зөвлөгөөг үзүүлсэн байна | Албан хаагчдад албан ажлын чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухай бүр хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан. | 2024.01.01-2024.06.10 | 100% |
| Зорилт 2. Үндсэн чиг үүргийн хүрээнд нийслэлийн удирдлагад хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх, хууль, шүүхийн өмнө төлөөлөх. | | | | | | | |
| 5 | Арга хэмжээ 2.1. Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэл хөтлөх, бүртгэлийг Нийслэлийн Прокурорын газарт тухай бүр хүргүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | | Бүртгэлийг хөтөлж, тухай бүр илгээсэн байна | Холбогдох хууль тогтоомжийн дагуу нийт 109 зөрчлийн гомдол, мэдээллийн бүртгэлийг хийж, тухай бүр хяналт тавих байгууллага буюу нийслэлийн Прокурорын газарт niislelprozurchil@gmail.com цахим хаягаар хүргүүлэн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн ажилласан. | 2024.01.01-2024.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|--|--|--|--------------------------------------|--|-----------------------------------|-------------|
| 6 | <p>Арга хэмжээ 2.2. Хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Засаг дарга, газрыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг Нийслэлийн Засаг дарга, газрын удирдлагын өмнө бүрэн хариуцах</p> | <p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p> | | <p>Итгэмжлэлээр төлөөлсөн байна</p> | <p>Байгууллагыг төлөөлөн тухай бүр шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тайлбар, нотлох баримтыг хүргүүлж, шүүх хуралд оролцон ажиллалаа. Тухайлбал: -Бүрэн цутгамал ХХК; -Хатанболор ХХК; -М.Цээцэндбаатар; -С.Ганзоригт -Бэсон ХХК -Р.Адъяасүрэн -Д.Ундрахсан, С.Базарваань -ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байна. Шүүхээс шийдвэрлэсэн байдлаас авч үзвэл, 71.4 %-д бүрэн шийдвэрлэгдсэн, 29.6%-хэрэг хянан шийдвэрлэгдэх шатанд хэлэлцэгдэж байна.</p> | <p>2024.01.01- 2024.06.10</p> | <p>100%</p> |
| <p>Зорилт 3. Төрийн байгууллагын дотоод засаглалын үйл ажиллагааг тогтмол сайжруулах, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх.</p> | | | | | | | |
| 7 | <p>Арга хэмжээ 3.1. Газрын үйл ажиллагаатай холбоотой гэрээ, эрх зүйн баримт бичиг, дүрэм, журам хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих</p> | <p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p> | | <p>Хяналт тавьж, ажилласан байна</p> | <p>1.Гэрээ: - Хөдөлмөрийн гэрээ - Байр ашиглалтын гэрээ - Төрийн байгууллагын цахим хуудас байршуулах цахим шуудан, домэйн нэр олгох үйлчилгээний гэрээ; зэргийг хууль тогтоомжид нийцүүлэн гэрээний хяналт хийв. 2.Эрх зүйн баримт бичиг: - Захиргааны акт буюу "Сахилгын шийтгэл оногдуулах тухай"</p> | <p>2024.01.01- 2024.06.10</p> | <p>100%</p> |

| | | | | | | | |
|--|--|--|--|--|---|--|--|
| | | | | | <p>газрын даргын 3-н тушаалын үндэслэх хэсгийг хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт хийж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу Сонсох ажиллагааг хийв.</p> <p>3.Бусад:</p> <ul style="list-style-type: none"> - Газрын даргын А тушаалын үндэслэх хэсгийг тухай бүр хууль тогтоомжид нийцүүлэн хяналт хийв. | | |
|--|--|--|--|--|---|--|--|

Зорилт 4. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах хүрээнд бүртгэл мэдээллийг хөтлөх

| | | | | | | | |
|---|--|------------|---|---------------------------|--|-----------------------|-----|
| 8 | Арга хэмжээ 4.1. Хууль тогтоомж, стандарт, нормын төсөлд өгсөн санал | Төрөл, тоо | - | Бүртгэлийг хөтөлсөн байна | <p>Байгууллагын хэмжээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хууль тогтоомж-7 хуулийн 22 зүйл, заалт - Дүрэм, журам-8 дүрэм журмын 33 заалт - Стандарт, норм-2 стандарт, норм дүрмийн 8 заалт <p>Зэрэг саналуудыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилсан байх бөгөөд хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Гачмаатай хамтран бүртгэл хөтөлсөн.</p> | 2024.01.01-2024.06.10 | 90% |
|---|--|------------|---|---------------------------|--|-----------------------|-----|

Зорилт 5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах.

| | | | | | | | |
|---|---|---------------------------------|--|--------------------------------------|--|---------------------------|------|
| 9 | Арга хэмжээ 5.1. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчлан таниулах, мэдлэг ойлголтыг төлөвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | | Арга хэмжээг зохион байгуулсан байна | Байгууллагын хэмжээнд жендерийн эрх тэгш байдлыг хангуулах, жендерийн мэдрэмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Харилцан хүндэтгэе" өдөрлөгийг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулж, Хувь хүний хөгжлийн институт ТББ-ын судлаач багш М.Мөнхжаргалыг урьсан бөгөөд "Хүндэтгэл ба эерэг харилцаа" сэдвээр лекц уншив. Мөн тус өдөрлөгийн хүрээнд Хүний эрх, шинэчлэн батлагдсан хууль тогтоомж, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах арга зүй" зэрэг сэдвийн хүрээнд лекц уншив. | 2024.01.01- 2024.06.10 | 100% |
| Зорилт 6. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх. | | | | | | | |
| 10 | Арга хэмжээ 6.1. ХАСХОМ (Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг)-ийг мэдүүлэх эрх бүхий албан хаагчид гаргаж өгөх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | | Холбогдох мэдээллийг өгсөн байна. | <ul style="list-style-type: none"> - Төрийн албаны тухай хуульд заасан "ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх" зарчмыг баримтлан хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна. - Хуульд заасны дагуу 2023 оны "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг холбогдох хууль тогтоомжийн хугацаанд https://meduuleg.iaac.mn цахим системд тайлагнаж, баталгааны маягтийг 2024 оны 02 сарын 01-ний өдөр эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. | 2024.01.01- 2024.06.10 | 100% |

Зорилт 7. Бусад нийтлэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын дэргэд ажиллах зөвлөлүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх.

| | | | | | | | |
|----|--|--|--|---|---|-----------------------------------|-------------|
| 11 | <p>Арга хэмжээ 7.1. Зөвлөлүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжүүлэх /Нийслэлийн хэмжээнд зохион байгуулж буй олон талт арга хэмжээ, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, спортын наадам, цасны баяр, мэтгэлцээн гэх мэт бусад тэмцээнд оролцох/</p> | <p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p> | | <p>Зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхитэй хамрагдсан байна</p> | <ul style="list-style-type: none"> - Байгууллагын дэргэдэх "Хүний эрх, жендерийн зөвлөл"-ийг байгуулж, Газрын даргын 2024.03.19-ний А/20 дугаар тушаалаар 2024 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэн ажиллав. - НЗДТГ-аас зохион байгуулж буй "Ногоон хот-иргэний оролцоо" мод тарих арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хандив өгөв. - НЗДТГ-аас зохион байгуулж буй "Хаврын их цэвэрлэгээ" аянд 2024.05.16-нд нэгдэж, цэвэрлэгээнд оролцов. - Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 385 жилийн ойн хүрээнд НЗДТГ-аас зохион байгуулсан UB QUIZ-385 танин мэдэхүйн тэмцээнд багаар оролцов. | <p>2024.01.01- 2024.06.10</p> | <p>100%</p> |
|----|--|--|--|---|---|-----------------------------------|-------------|

Зорилт 8. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх.

| | | | | | | | |
|----|--|--|--|---|---|-----------------------------------|-------------|
| 12 | <p>Арга хэмжээ 8.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах</p> | | | <p>Чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна</p> | <p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.</p> | <p>2024.01.01- 2024.06.10</p> | <p>100%</p> |
|----|--|--|--|---|---|-----------------------------------|-------------|

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|-----|---|---------------------------------|--------------|-------------------------------|---|--------------------------|-----------------|
| 1. | Газрын дүрмийг шинэчлэн батлуулах хүрээнд Дүрмийн төсөл, Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулж, батлуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | Захирамжийг батлуулсан байна. | Тус арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл, дүрмийн төслийг боловсруулж, саналын хуудаст санал аван НЗД-ын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/654 дугаартай "Газрын дүрмийг шинэчлэн батлах тухай" захирамжийг батлуулан ажилласан. | 2024.01.01-2024.06.10 | 100% |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|-----|---|----------------------------|---------------------|--------------|-------------------------|--------------------------|-----------------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1.1. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад хамрагдах. | Сургалтад хамрагдсан байна | - | - | - | 2024.01.01-2024.06.10 | - |

| | | | | | | | |
|--|--|--|--|---|---|------------------------------|-------------|
| | <p>Арга хэмжээ 1.2. Мэргэжлийн ур чадвар, мэдлэгээ сайжруулан идэвх санаачилгатай ажиллах, газрын хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээ, сургалтад бүрэн хамрагдах.</p> | <p>Арга хэмжээ, сургалтад хамрагдсан байна</p> | | <p>Арга хэмжээ, сургалтад хамрагдсан байна</p> | <p>Албан тушаал, чиг үүрэгтэй холбоотойгоор дээд шатны байгууллагуудаас зохион байгуулсан болон хууль, эрх зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх хүрээнд холбогдох сургалтад хамрагдан ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн талаарх сургалтад 2024.01.12 хамрагдав. - НЗДТГ-ын, Хууль, эрх зүйн газраас хуулийн мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан Төрийн худалдан авах ажиллагаа болон нийслэл улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, дагалдаж батлагдсан 23 хуулийн талаарх сургалтад 2024.04.12-ны өдөр; - ЗГХЭГ, Удирдлагын академитай хамтран зохион байгуулж буй "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл"-ийн талаарх сургалтад 2024.05.30-ны өдөр - Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан "Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх" сургалт, хэлэлцүүлэгт 2024.03.06-ны өдөр; <p>Тус тус хамрагдав.</p> | <p>2024.01.01-2024.06.10</p> | <p>100%</p> |
| | <p>Арга хэмжээ 1.3. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны талаар гарын авлага боловсруулах</p> | <p>Гарын авлагыг боловсруулсан байна</p> | | <p>Сэдвийн хүрээг тодорхойлж, судалгаа хийсэн байна</p> | <p>Барилга, дэд бүтцийн салбарт хамаарах "Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны онцлог" сэдвээр гарын авлага боловсруулахаар шийдвэрлэв. Гарын авлагыг хууль тогтоомжийг тайлбарласан хэлбэрээр дараах бүтцээр боловсруулахад бэлтгэж байна:</p> | <p>2024.01.01-2024.06.10</p> | <p>100%</p> |

| | | | | | | | |
|--|--|--|--|--|---|--|--|
| | | | | | -Эрх бүхий албан тушаалтны эрх зүйн байдал, эрх үүрэг; -Зөрчлийн талаарх ойлголт; -Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тохиолдол шинжлэх арга зүй; | | |
|--|--|--|--|--|---|--|--|

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
 ДАРГА
 (Албан тушаал)


 /Б.МӨНХБАЯР/
 (Нэр, гарын үсэг)

2024.06.10

 (Огноо)

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН АХЛАХ
 МЭРГЭЖИЛТЭН
 (Албан тушаал)


 /Б.САРАНГЭРЭЛ/
 (Нэр, гарын үсэг)

2024.06.10

 (Огноо)